

ОЛОН УЛСЫН  
ХАРИЛЦАА, ГАДААД  
БОДЛОГО

**ДЭЛХИЙН БОЛОН АЗИ, НОМХОН  
ДАЛАЙН ОРНУУДЫН ЭДИЙН  
ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА,  
ИНТЕГРАЦ**

**Б. Түмэн\***

Колонийн систем 50-иад онд задарсны дараа 170 шахам орон хөгжлийн түргэн зам хайсан боловч оносон нь 10 хүрэхгүй. Азийн баруудын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн нууц нь нэгд, тэд 80-90-ээд онд хөгжлийн ирээдүйн үе шатанд ноёлох технологийг бүр 60-аад онд зөв зохион байгуулалт, механизм олж чадсанд байгаа юм.

Бид анх 1961 оноос эхлэн 15—20 жилээр хөгжлийн үзэл баримтлал, хэтийн төлөвлөгөө, прогноз, ерөнхий схем боловсруулсан боловч нэгд, шинжлэх ухаан-технологийн дэвшлийг гүйцэд үнэлж, түүнд зохицох бодлого байгаагүй, хоёрт, дэлхий нийтийн хөгжлийн хандлагыг анхаардаггүй хаалттай байсан дутагдлыг давтаж болохгүй.

Социалист систем, ялангуяа түүний гол түшиг тулгуур болсон ЗХУ задарснаар дэлхийд цэрэг улс төрийн цоо шинэ нөхцөл байдал бий боллоо. Улс төрийн бодлоготнуудын хувьд үйл явц ажиглан харж амжихааргүй асар хурдацтай өрнөж байна гэж ярьж байгаа боловч эдийн засагчдын хувьд энэ бол зүй тогтолт, хүлээж харж байсан зүйл билээ. Эдгээр үйл явцын гол суурь үндэс нь хүн төрлөхтөн байгалийг эзэгнэж үйлдвэржүүлэх загвараас салж шинэ мянган жилийн эхэнд соёл иргэншлийн шинэ загварт шилжихэд тулж очоод байгаатай холбоотой. Гуравдагч мянган жилд бий болох шинэ соёл иргэншлийн тухай олон янзын таамаглал буй.

Үүнийг 3 түвшинд ангилан авч үзэж болно.

Нэгд, хувь хүмүүсийн таамаглал, Дж. Белл, Дж. Гелбрейт, З. Бзежинский, Р. Арон нарын 70-аад онд ихэд нэрд гарч байсан таамаглалуудын оронд Далласын Их сургуулийн проф. Рави Батр, «Мегатенденци. Год 2000» ном бичсэн америкийн футуролог Д. Несбит, П. Абурден «Гурав дахь давалгаа», «Хүчний харьцаа» зэрэг ном бичсэн А. Тоффлерийн таамаглалууд асар их дуулиан тарьж байна.

Хоёрт, Дэлхий дахинаа нэр хүндтэй «Ромын клуб», «Ресурсы для будущего» корпорац, Гудзоны институтын групп, нарийвчилсан судалгааны олон улсын холбоо (ИФИАС) зэрэг засгийн газрын бус эрдэмтдийн байгууллагын судалгааг хэлж болно.

Ийм байгууллагууд хүн төрөлхтний ирээдүй, улс төрийн бодлогын хандлага, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн одоогийн байдал, хэтийн төлөвийн талаар иж бүрэн судалгаа таамаглал хийдэг уламжлал тогтоод 20 гаруй жил болж байна.

Энэ бүлэгт Японы эдийн засгийн төлөвлөлтийн товчооны гол уураг тархи болсон NIRA зэрэг футурологийн судалгааны мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт таамаглалуудыг бас хамруулж болно.

Ромын клубээс «Пределы роста» (Өсөлтийн хязгаар), «Человечество на перепутье» (Хүн төрөлхтөн салаа замын эхэнд), «Пересмотр между народного порядка» (Олон улсын дэг журмыг шинэчлэхүй), «Цели для человечества» (Хүн төрөлхтний өөрийн зорилго), «За пределами расточительства» (Үрэх зарахын цаана) гэх мэт 20 гаруй илтгэл гаргасан бөгөөд хамгийн сүүлд 1991 оны IX сард «Первая глобальная ре-

\*Эдийн засгийн ухааны дэд доктор

волюция» буюу «Хүн төрөлхтний анхны хувьсгал» илтгэл гарчээ. Энэхүү илтгэлийн гол дүгнэлт нь «Өнөөдөр нийгмийн амьдралын арга хэрэгслүүдийг тодорхойлж буй улс төр, эдийн засгийн онолууд тохирохоо больж хямралд орлоо. Энэ бол зөвхөн марксизмыг хэлж байгаа хэрэг бус.

Ардчилал өнөөгийнхөө хэлбэрээр байвал ирээдүйн зорилтыг шийдвэрлэхэд тус болж чадахгүй. Улс төрийн намуудын үйл ажиллагаа сонгуулийн кампани, өөртөө хүмүүсийг татахад хэт автаж, бүгд ардчиллыг гол лоозонгоо болгодог боловч үнэн хэрэгтээ ардчилал тэдний үйл ажиллагааны золиос болж байна. Сүүлийн хорь гаруй жил ардчиллын үндсэн дээр гарч ирсэн улс төрийн засаглал нэг нь ч тулгарч байгаа глобал асуудлыг шийдвэрлэх талаар юу ч хийсэнгүй, чадах ч үгүй юм байна.

Олон орон өнөөдөр зах зээлтэй итгэл найдвараа холбож байна. Гэтэл зах зээлийн механизмаар глобал асуудлыг шийдвэрлэхгүй, зөвхөн зах зээлд түшиглэдэг ертөнцөөс ирээдүйн нийгэм төрж хэзээ ч чадахгүй. Зах зээл шинэчлэлд мэдрэмтгий боловч гүн гүнзгий, стратегийн зорилт, урт хугацааны концепцийг хэрэгжүүлэхэд найдвартай хэрэгсэл биш гэжээ.

Гуравт, НҮБ, түүний системийн байгууллагуудын албан ёсны судалгаа, дүгнэлт, баримт бичгүүд их чухал. НҮБ-ын ЕА-ийн 45-р чуулган Олон улсын хөгжлийн дөрөв дэх арван жилийн стратеги, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, ялангуяа хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлт, хөгжлийг түргэтгэх тухай тунхаглал, 2000 он, түүнээс цаашхи хугацаан дахь АНДЭЗНК-ийн бүсийн нийгмийн хөгжлийн стратеги гэх мэт баримт бичгүүдэд тусгагдсан дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиглэл, хандлага, арга хэрэгслийн тухай дүгнэлтүүд ач холбогдолтой байдаг.

Эдгээр болон бусад судалгаанд тулгуурлан гурван зүйл хэлэхийг хүсч байна.

Нэгд, дэлхий, бүс нутгийн аж ахуйн хэлхээ холбоо интернационалчлагдаж, шинжлэх ухаан-техникийн хувьсгал нийтийг хамарсан шинжтэй, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгсэл зарчмын цоо шинэ үүрэгтэй болж, манай гаригийн нөөц, хүрээлэн буй орчны байдал, шинэ тулгар хөгжиж байгаа ертөнцийн нийгмийн асуудал хүн төрөлхтний санаа сэтгэлийг зовоосон хурц асуудал болоод байна.

Хүйтэн дайн төгсгөл болсноор эсрэг, тэсрэг хоёр туйлд төвлөрсөн эдийн засаг, улс төрийн бодлогын гажуудал аажмаар арилж, уур амьсгал нь зөөлөрч хөрөнгө хүчийг зөвхөн хүний төлөө зориулах сайхан бололцоог нээж байна. Үүнтэй нягт холбоотойгоор нийгэм, улс төрийн амьдралд эдийн засаг, шинжлэх ухаан-техник, мэдээлэл, нийгэм, соёлын харилцаа зэрэг уламжлалт бус хүчин зүйлүүдийн гүйцэтгэх үүрэг ихээхэн өсөж байна. Бүх хөрөнгө хүч сөрөг төвлөрөлд захирагдаж, хүйтэн дайны аюул бодитой заналхийлж байсан тэр үед ч шинжлэх ухаан, техник технологийн хөгжил бүс нутгуудад жигд биш ч гэсэн зүй тогтлоороо өрнөж улмаар интеграцичлах процесс явагдаж байсан юм. Эрдэм оюун их шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөн хүрээтэй явуулах болсоноор нэг талаас хөдөлмөрийн шинж чанар өөрчлөгдөж ахуйн хэрэгцээг хангах, нэр төрөө өргөх, улмаар улс төрийн амьдралд нөлөөлөхөд чиглэх хандлагатай болсон байна,

Хэмнэлттэй, эрчимтэй технологитой үйлдвэржүүлэлт, автоматжуулалт, мэдээлэлжүүлэлт нь дэлхий дахинд хүмүүнлэг үзлийг бүхэл бүтэн нийтлэг болж тогтооход ихээхэн нөлөө үзүүлэх боллоо.

Нарийн технологи бүхий үйлдвэрлэлийн аппараттай болох нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах шинэ түлхэц болохын дээр ширүүн өрсөлдөөнд ялах нөхцөл болно. Үүний дүнд материаллаг бус үйлдвэрлэлийн хүрээний үүрэг роль материаллаг үйлдвэрлэлийнхээс илүү болж нийгмийн хуримтлал улам бүр баялгийн материаллаг бус элементийн (мэдээллийн) хуримтлалын хэлбэртэй болно. Эдийн засгийн хөгжлийн шинж төлөв үндсээрээ өөрчлөгдөж үйлчилгээний хүрээнд ажиллагсад, хөрөнгө оруулалт ихээхэн нэмэгдэж эдийн засагт материаллаг бус зардлын эзлэх хувь өснө. Материаллаг бус үйлдвэрлэл дотор мэдээлэл боловсруулдаг ажилтан голлох хэв маяг болж, материаллаг үйлдвэрлэлд гүйцэтгэх үүрэг нь эрс нэмэгдэнэ.

Шинжлэх ухаан-техникийн ийм хувьсгал нь хүний эд материалын болон оюун санааны боломжийг асар ихээр өргөжүүлэн тэлэх эхлэлийг тавихын зэрэгцээ нийгмийн харилцааг боловсронгуй болгох, сэтгэлгээг өөрчлөн залах, шинэ психологийг бий болгох, эрчимтэй чанарыг аж төрөх ёс, ахуйн хэм хэмжээ болгон тогтоохтой холбоотойг туршлага нэгэнт харуулж байна.

Шинжлэх ухаан-техникийн дэвшил ийнхүү нийгмийн хөгжлийн хууль, түүний нийгмийн утга агуулгыг өөрчилж чадахгүй боловч дэлхий дахинд болж байгаа бүх процесс, түүний зөрчилд асар их нөлөөлж байгааг бид харгалзах ёстой.

Дэлхийн хөгжлийн ийм хандлага манай үндэсний хөгжлийн үзэл баримтлалд, юуны өмнө бүтцийн бодлогод тусгалаа олох ёстой.

Нөгөө талаар үүнтэй холбоотойгоор хүн хөрөнгө оруулалтын гол объект болж байгаа хандлагыг бас заавал тусгаж хэрэгжүүлэх ёстой.

Хоёрт, улс гүрэн бүр өөрийн хөгжил дэвшлийг дэлхий нийтийнхтэй уялдуулахыг эрхэмлэж аль нэг системийн эрх ашгийг хамгаалах гэхээсээ өөрийнхийгөө урьтал болгоход анхаарч байна. Монгол улс энэ бололцоог ашиглаж үндэснийхээ эрх ашгийг бие дааж тууштай хамгаалахын тулд хүчний төвлөрөл, харьцааг мэдрэх, түүнийг тэнцвэржүүлэхэд онцгой анхаарах ёстой.

Өдгөө улс төрийн хувьд дезинтеграц ажиглагдаж байгаа боловч эдийн засгийн хувьд интеграцлах үйл явц эрчимтэй явагдаж байна. Европын орнууд нэгдсэн зах зээлтэй болж, АНУ, Канад, Мексик улс, хамтран хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр «НАФТА» байгуулж, «Африкийн эдийн засгийн хамтын нийгэмлэг» зохион байгуулах хурал болж «Арабын эдийн засгийн блок» байгуулах уриа дуудлага сонсогдох болов.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь нэг талаар интеграцыг илэрхийлж байгаа боловч нөгөө талаар эдийн засгийн протекционизм нэг улсын хүрээнээс хальж бүсийн хүрээнд шилжиж байгаа байдал ажиглагдаж байна. Жишээг холоос эрэх хэрэггүй. АНУ ЕЭЗХН хоёр 1992 оны турш дарс нийлүүлэх асуудлаар худалдааны дайн явууллаа. Хэрэв энэ маргаан даамжирвал олон улсын худалдааг чөлөөлөх асуудлаар ТХЕХ (GATT) -ийн хүрээнд 6 жилийн турш явагдаж буй олон талын яриа хэлэлцээ (Уругвайн үе шат) -ний явцад туйлын сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Энэ бол дэлхий ертөнцийн харилцаа үзэл суртал, түүнээс үүдсэн цэрэг улс төрийн сөргөлдөөнөөс эдийн засгийн өрсөлдөөнд шилжиж байгааг нотолж байна.

Хөгжлийн хувьд хамгийн ирээдүйтэй бүс нутаг нь АНДБ юм. Тус бүс нь 2,15 тэрбум хүн амтай, 62 сая ам дөрвөлжин километр нутагтай, жилд 12,5 триллион ам долл. бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь дэл-

хийн хүн амын 40 %, газар нутгийн бараг тал хагас, нийт бүтээгдэхүүний тал илүү болж байна. 2000 он гэхэд эл бүс нутгийн хүн ам, 2,5 тэрбум болж 16 трл. ам. долл. бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь дэлхийн нийт бүтээгдэхүүний 55 хувь болох юм.

Энд бас бүлэглэх үйл явц явагдаж байна. АНУ, Япон, Хятад, зэрэг их орнууд, АСЕАН-ы орнууд тэргүүлэх байр суурь эзлэхийн төлөө өрсөлдөж байна. Сүүлийн жилүүдэд АПЕК, ПЕКК зэрэг бүлэглэлүүд байгуулагдаж 1990 оны 12 сард Малайз зүүн Азийн эдийн засгийн бүлэглэл байгуулах санал дэвшүүлж АНУ-г сандаргасан. Энэ нь хойд Америк, баруун Европын бүлэглэлийн эсрэг арга хэмжээ болох ажээ.

Монгол энд өөрийн байр сууриа олох ёстой. Үүнд Төв Ази гэдэг бүс нутаг бас гарч ирсэнийг бодолцох ёстой.

Энэ бүс нутагт нөлөөтэй томоохон орнуудын хөгжлийн прогнозыг харгалзах ёстой. Жишээ нь БНХАУ барагцаалбал 30 жилийн дараа 2020 он гэхэд үндэсний нийт бүтээгдэхүүний төвшнөөр АНУ-ыг гүйцнэ гэж хятад-америкийн хамтарсан судалгаагаар тооцсоныг хайхрахгүй байж болохгүй.

Гуравт, нийгмийн хөгжлийн шинэ хэлбэрийг эрж олох, нийгэм, соёлын хоцрогдлыг даван туулсан дэлхий дахины туршлагыг ашиглах асуудал тулгамдсан зорилт болж байна. Энэ үүднээс авч үзвэл хэдхэн жилийн өмнө ижил төвшинд байсанд мөртөө биднээс хол түрүүлсэн «Шинэ үйлдвэржсэн орнууд»-ын туршлага ихээхэн сонирхол татаж байгаа юм.

Эдгээр орны хөгжсөн замыг судлан үзэхэд ямар нэгэн «гуравдах зам»-ын тухай биш, шинэ үйлдвэржсэн орнуудын нэгдэх (Өмнөд Солонгос, Тайвань, Гонконг, Сингапур) болон хоёрдахь (Малайз, Тайланд) давалгаа гэгдэх орнууд түүхэн хоцрогдлоо даван туулахад хэрэглэсэн өвөрмөц арга барилын тухай ярих нь зүйтэй юм байна гэдэг дүгнэлт гардаг. Тухайлбал үндэсний зах зээлийг түргэн хөгжүүлж дэлхийн аж ахуйтай уялдуулдаг, эдийн засаг, улс төрийн асуудлыг шийдвэрлэхэд төрийн үүрэг роль их өндөр боловч эдийн засгийн хөгжилд саад болохгүй, харин ч тус дэм болдог тэр арга хэрэгслийг авч үзэх хэрэгтэй болж байна.

Үүнтэй холбогдуулан Ази дахь «өөрчлөн байгуулалтын концепц» ийн тухай авч үзвэл зохино.

Энд өөрчлөн байгуулалтыг хориглон хамгаалах, бодит гэж хоёр чиглэлээр ялгаж ойлгодог. Бодит өөрчлөн байгуулалт нь ашгийн илүү өндөр нормтой салбарт ресурсээ төвлөрүүлэх зорилгоор эдийн засгийн үйл ажиллагааны үр ашигтай чиглэлүүдийг сонгож авахыг хэлэх бөгөөд хөгжиж буй орнуудын сонирхолд илүү нийцдэг. Төлөвлөх удирдах байгууллагууд, аж ахуйн удирдах ажилтан бизнесменүүд ирээдүйд ашиг өгөх үйл ажиллагааг зөв, зоримог явуулах чадвартай байх ёстой. Гадаад нөхцөл байдал түргэн өөрчлөгдөж байгаа өнөө үед үйлдвэрлэлийн шинэ салбарыг зөв үнэлэн сонгож зоримог ажилласан, эсвэл одоогоор зардал ихтэй боловч ирээдүйд их ашиг өгч чадах шинэ технологийг нэвтрүүлж чадсан орнууд амжилт олсон. Тийм учраас бодит өөрчлөн байгуулалтад хөрөнгө оруулах, үйлдвэрлэлийг урамшуулах хоёрыг тэнцүү хувилбар гэж үздэг. Шинэ салбарыг хөгжүүлэх нь аз туршсан шинжтэй, ирээдүй тодорхойгүй байдаг зэргээс ийм чиглэлийн хөрөнгө оруулалтыг илүү урамшуулахыг шаардана. Энэ нь их төлөв төрөөс оролцох шалтгаан болдог. Судалгаа боловсруулалтын төслүүдийг дэмжиж санхүүжүүлэх, бизнес эрхлэлтийг хөгжүүлэх нь хөгжиж байгаа орнуудын хувьд тэргүүлэх ач холбогдолтой байна.

Хориглон хамгаалах өөрчлөн байгуулалт нь өрсөлдөх чадвараа алдаж буй салбараа сэргээн өндийлгөж эдийн засгийн өсөлт, ашгийн хангалттай нормыг бий болгоход шаардагдах зардал үйлдвэрлэлийн тийм шинэ харьцаа тогтоохыг хэлнэ. Уналтад орсон салбараа аврах зорилгоор хөгжингүй орнуудаас бүтцийн зохицуулалт хийсэн. Учир нь 70-аад оны эхэнд боловсруулах салбарын үйлдвэрлэл, ажил эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмж буурч «үйлдвэржилтээ алдах» аюул тулгарлаа гэж сэтгэл зовницгоосон.

Дэлхийн эдийн засагт харьцангуй давуу тал хэрхэн өөрчлөгдөж байгаад үндэслэн аж үйлдвэрийн холбогдох салбар, технологийг сонгон авч хөрөнгө хүчээ хуваарилан эдийн засгаа өөрчлөн байгуулж чадсан сонгодог жишээ бол Япон улс юм. Байгалийн баялаг ховор Япон улс цэвэр бүтээгдэхүүн их өгдөг салбаруудыг дэмжин хөгжүүлэх замаар төрөлжилтийн бүтцээ байнга боловсронгуй болгож чадсан. Ингэхдээ үйлдвэрлэлийн дөрвөн үе шатыг дамжсан гэж үздэг. Үүнд: шинэ эрэлт бий болгож технологи шинэчлэх боломж олгодог шинэ бүтээгдэхүүнийг импортлох, импортлож байсан зүйлээ өөрөө үйлдвэрлэдэг болох, экспортлох, хөгжиж байгаа бусад орнууд уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж сурахаар реимпорт хийх гэсэн үйлдвэрлэлийн энэ циклийг японы эдийн засагч К. Акамацу Ganko keitai буюу «галуун цуваа» гэж нэрлэсэн.

«Галуун цуваа» хэмээх энэхүү загварыг японы аж үйлдвэрийн хөгжил, олон улсын хөдөлмөрийн хуваарийг тайлбарлахад хэрэглэдэг. Олон улсын, ялангуяа зүүн, Зүүн өмнөд Азийн орнуудын хувьд «галуун цуваа»-ны онол нь харьцангуй давуу талыг байнга дахин хуваарилж илүү өндөр хөгжилтэй орноос бага хөгжилтэй орон руугаа шилжүүлэхийг хэлдэг. Өөрөөр хэлбэл илүү хөгжилтэй орон нь харьцангуй тэргүүний салбарын үйлдвэрлэл экспортоо бага хөгжилтэй орон руу шилжүүлж харилцан нөхдөг эдийн засагтай болно гэсэн үг. Нэгд, хөдөлмөр зарцуулалт ихтэй, технологийн хувьд хоцрогдож байгаа салбарт нэгж хөдөлмөрт ногдох зардал өсөх хэрээр илүү хөгжилтэй орнууд өрсөлдөх чадвараа алдаж түүнийг эрхлэхээ болино. Харин бага хөгжилтэй оронд цалин хөлс багатай ажилчдын туршлага дадлага хуримтлах хэрээр хөдөлмөрийн бүтээмж өсч харьцангуй давуу тал нь нэмэгдэж тэр салбарын бүтээгдэхүүнийг экспортлох боломжтой болдог.

Хоёрт, үйлдвэрлэлийг шилжүүлэн байрлуулахдаа илүү хөгжилтэй орон шууд хөрөнгө оруулалт хийх буюу технологио шилжүүлэн өгдөг.

Гуравт, энэ ажилд капитал, технологи, сэлбэг хэрэгсэл материалаар хангаж орон нутгийн ажиллах хүч, бүтээгдэхүүнийг гүйцээн боловсруулах, савлаж баглах шатанд орон нутгийн зарим материал хэрэглэдэг үндэстэн дамнасан корпорацийг татан оролцуулахаар тэд бүтээгдэхүүнийг өөрсдийн худалдааны сүлжээгээ ашиглан экспортлодог. ҮДК-ыг импорт орлуулах, экспортлох аль ч шатанд татан оролцуулж болно.

Дөрөвт, Бүс нутгийн дотоод худалдааг хөгжүүлэх үндсэн дээр хөгжиж байгаа бусад орны зах зээлд бүтээгдэхүүнээ гаргадаг байна. Энэхүү загварыг хэрэгжүүлэхэд тэр салбарыг эрхэлж буй бусад орны томоохон үйлдвэр, компани саад хийх, шаардлагатай зарим нөхцөл, харилцан бие биеэ нөхөх хөгжлийн төвшин хүрэлцэхгүй байх зэрэг шалтгаанаас бэрхшээл учирч болохыг онцгой анхаардаг байв.

Ази дахь өөрчлөн байгуулалтын явц, ирээдүйг судлан үзэхэд бүтцийн хувьд хөдөө аж ахуйн эзлэх хувь буурч аж үйлдвэрийнх, хурдац нь удаан боловч бас үйлчилгээний салбарын эзлэх хувь өсч байгаа зураг харагдаж байна. Тэгэхдээ энэ нь аж үйлдвэр, үйлчилгээ илүү хурдацтай өссөнөөс үүдсэн харьцангуй өөрчлөлт юм. Гэтэл ажил эрхлэл-

тийн бүтэц үйлдвэрлэлийн энэхүү өөрчлөлтийг тусгахгүй, хөдөө аж ахуйг эрхлэгчдийн хувь төдийлөн буурахгүй байгаа нь Азийн орнуудын онцлог юм. Ийм учраас хөдөө аж ахуйн секторт хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нь өөрчлөн байгуулалтын нэг зангилаа асуудал мөн гэж үзэж байна. Мөн үйлчилгээний эзлэх хувийг үйлдвэрлэлийн хэмжээ, ажил эрхлэлтэд аль алинд нь нэмэгдүүлэхийг чухалчилж байна. 80-аад оны эхээр болсон томоохон уналт өөрчлөлтөд тэсэн үлдэсний шалтгааныг хөдөө аж ахуйн секторын хөгжил, гадаад худалдаанаас харьцангуй бага хамаардагаар тайлбарлаж байна.

Өөрчлөн байгуулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд зарим нөхцөл бүрдүүлэх шаардлагатай бөгөөд ийм урьдач нөхцөлийн тоонд хөдөө аж ахуйд өөрчлөлт хийх, нөөц ресурсийг дахин хуваарилж түргэн болгох, түүхий эд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний протекционизмыг даван туулж бусад салбартай тэнцвэртэйгээр хөгжүүлэх зэрэг асуудал орж байна.

Хөдөө аж ахуй дахь өөрчлөн байгуулалтад нэг талаас нэмэгдэл (ахиуц) өртөгтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түргэн хөгжүүлэх замаар хөдөө аж ахуйн бүтцийг өөрчлөж агро эдийн засгаас индустрал эдийн засагт шилжих, нөгөө талаас «ногоон хувьсгал» нөлөөлөөгүй, бүтээмж багатай газарт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хурдацыг нэмэгдүүлэхэд төрөөс эрчимтэй оролцохыг ойлгож байна.

## **ЯПОН БА АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ**

(90-ээд он)

**О.Оюунгэрэл\***

Олон улсын дэг журмын хэм хэмжээ шинэчлэгдэж, урьдын Америк, Зөвлөлтийг голлосон хоёр туйлт системээс олон туйлт систем рүү шилжих үйл явц эхлээд байна. Эдгээр шинэчлэлт өөрчлөлтийн үйл явц Европт эхлэн өрнөж, аажмаар Ази, Номхон далайн бүс нутаг руу шилжин ирж байна. Ази, Номхон далайн бүс нутагт урьд Алс Дорнод гэж нэрлэгдэж байснаа одоо Номхон далайн баруун хэсэг гэгддэг болсон Зүүн Өмнөд Ази, далайн орнууд хамаарна. Уг бүс нутагт амьдрал ахуй, шашин шүтлэг, бичиг үсэг өөр өөр олон үндэстэн оршин суудаг билээ. Тухайлбал, нэг хүнд ногдох үндэсний орлого 23 мянган америк доллар бүхий Япон болон 130 орчим доллар ноогддог Камбож ч хамран орж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийг бүхэлд нь «Дэлхийн аж үйлдвэрийн бааз» болгон хувиргахад Японы аж үйлдвэрийн хөгжил их хувь нэмэртэй билээ.

Япон улс дэлхийн тавцан дээр гарч ирсэн цагаас хойш дипломат бодлогынхоо зарчмыг:

1. НҮБ-ын төвийг сахих бодлогыг баримтлах
2. Дэлхийн чөлөөт улс орнуудтай хамтын ажиллагаа явуулах
3. Азийн орны хувьд энэ бүс нутагт байр сууриа бэхжүүлэх явдал гэж тодорхойлсон.

\*ДДОУС-ийн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан